

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД НИЙГМИЙН ЭНТЕРПРЕНЕРИЙГ АШИГЛАХ ОНОЛЫН СУДАЛГАА

Ч. Гэрэлээ
Бакалавр оюутан

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

happygegee@yahoo.com

Хураангуй: Дэлхийн бүх орон нийгмийн үйлчилгээний зохистой бодлого явуулах тал дээр анхаарч ирсэн. Халамжийн үйлчилгээний жишээн дээр дурдахад халамжийн системийн зарцуулалтыг хумих, халамж авдаг иргэдээ орлоготой болгож цөөлөх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлого явуулж байгаа бөгөөд халамжийн системээ төр ганцаараа үүрэх бус хувийн хэвшлийн байгууллагын оролцоотойгоор зохицуулалт хийх, бусад орны халамжийн системийн сайн туршлагыг авч хэрэгжүүлэх гээд олон төрлийн арга хэмжээг авч байна[1]. Засгийн газар дангаараа ядуурлын асуудлыг шийдэж чадахгүй учраас нийгмийн халамжийн шинэчлэлд төрөөс гадуур корпорацууд, олон нийтийн байгууллага, нийгмийн үйлчилгээ эрхлэгчид, хувийн байгууллага, бизнес эрхлэгчид багтаж байгаа юм. Энэ нь халамжит төрөөс татгалзах бус харин стратегийн үүргээ дахин тодорхойлох явдал юм. Өнөө үед өөрчлөлтийн гол агуулга нь иргэдэд төрийн үйлчилгээг аль болох бага зардлаар хамгийн үр дүнтэй хүргэх, аливаа хүнд суртлыг багасгахад чиглэх болсон. Барууны улс орнуудын хувьд энэхүү арга хэмжээнд нийгмийн энтерпренер болон энтерпренерийн байгууллагуудаар дамжуулан халамжийн системээ амжилттай шинэчилж байна.

Түлхүүр үгс: Инновац, капитал, хувийн хэвшил, төр

УДИРТГАЛ

Нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнүүд ядуурлыг бууруулахад чиглэгдэж буй боловч эдийн засгийн өсөлтийг дагаж ядуурлын хамрах хүрээ дорвитой буурахгүй, харин ч ядуурал олон хэлбэртэй болж хүн амын зарим хэсэг нь орлогын төдийгүй боловсролын, сэтгэлгээний ядууралд нэрвэгдэж, ядууралтай эвлэрч, түүнээс гарах эрмэлзлээсээ няцах хандлагатай болж байгаа нь санаа зовоох асуудал болж байна. Өөрөөр хэлбэл, зорилтот бүлэгт нийгмийн

халамжийн мөнгөн тэтгэвэр, тэтгэмж олгохоос гадна нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж, үе дамжсан ядуурлаас сэргийлэх шаардлагатай байна. Нийгмийн энтерпренер гэж нийгэмд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, нийгмээ өөрчлөхийн тулд бизнесийн зарчмуудад тулгуурлан тухайн ажлыг, байгууллагыг зохион байгуулах, бүтээх ба удирдах хүнийг хэлнэ [2]. Бизнесийн энтерпренер үр дүнгээ орлого ба ашгаар хэмждэг бол нийгмийн энтерпренер нийгэмд бүтээсэн эерэг үр дүнгээр хэмждэг.

Энэ 2 ойлголт үзэл баримтлалын хувьд хоорондоо ялгаатай боловч хоорондоо ижил төстэй зарим зүйлийг хоорондоо хуваалцаар байдаг. Нийгмийн энтерпренерүүд ихэвчлэн сонгодог бизнес эрхлэгч шиг агшийнхаа түвшинг өсгөхөөс илүүтэйгээр нийгмээ томруулж, хүчирхэгжүүлэхийг хүсдэг. Орчин үеийн нийгмэд нийгмийн энтерпренер нь нийгэмд олж болох ашиг тусад анхаарлаа төвлөрүүлдэг бизнес эрхлэх хэлбэр лүү илүү чиглэж байна. Энгийнээр хэлэхэд нийгмийн капиталыг нийгэмд эерэгээр нөлөөлөх байдлаар бизнес эрхлэх нь нийгмийн томоохон хүчин зүйл болно. Нийгмийн энтерпренер нь нийгмийн тулгамдсан асуудал нийгэмтэй хэрхэн холбогддог талаар илүү бодитой нарийн олж харж тэрхүү асуудлыг шийдвэрлэх шинэлэг шийдлийг боловсруулж боломжит нөөцийг дайчладаг. Тиймээс ч энэхүү чиглэлээр ажилладаг байгууллагууд ашиг орлогоо нэмэгдүүлэхээс илүүтэйгээр нийгмийн сэтгэл ханамжийн олотыг нэмэгдүүлэхэд анхаардаг[3].

Нийгмийн халамжийн үйлчилгээний өнөөгийн байдал

Монгол улсын нийгмийн халамжийн салбарт өнөөгийн тулгамдаж буй зарим асуудлыг авч үзвэл:

-Нийгмийн халамжийн нийт зардал өндөр хэдий ч ядуу, амьжиргаа багатай зорилтот бүлгийн хүн амд очих халамжийн тэтгэмж, тусламжийн хэмжээ бага

байна. Тухайлбал 5 ам бүлтэй нэн ядуу өрхөд (2 том хүн, 3 хүүхэдтэй) сард 45,5 мянган төгрөгийн хүнсний эрхийн бичгийн дэмжлэг үзүүлж байна. Халамжийн сангаас олгох тэтгэмж, тусламжийн хэмжээ нь ядуу өрхийн сарын амьжиргааны хэрэглээний дунджаар 9.8 хувьтай тэнцэж байна. Энэ нь дэлхийн ихэнх улс орнуудтай харьцуулахад 2-3 дахин, Европ, Төв Азийн зарим улс орнуудтай харьцуулахад 5-6 дахин бага байна.

-Нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнүүд ядуурлыг бууруулахад чиглэгдэж буй боловч эдийн засгийн өсөлтийг дагаж ядуурлын хамрах хүрээ дорвитой буурахгүй, харин ч ядуурал олон хэлбэртэй болж хүн амын зарим хэсэг нь орлогын төдийгүй боловсролын, сэтгэлгээний ядууралд нэрвэгдэж, ядууралтай эвлэрч, түүнээс гарах эрмэлзлээсээ няцах хандлагатай болж байгаа нь санаа зовоох асуудал болж байна. Өөрөөр хэлбэл, зорилтот бүлэгт нийгмийн халамжийн мөнгөн тэтгэвэр, тэтгэмж олгохоос гадна нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж, үе дамжсан ядуурлаас сэргийлэх шаардлагатай байна.

-Нийгмийн халамжийн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн дийлэнх хэсгийг 2013 оноос эхлэн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг болсон. Энэ нь төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутагт төсвийн эрх мэдлийг олгох зорилготой байсан. Гэвч

зарим тохиолдолд орон нутгийн төсөвт ачаалал үүсгэх, төсвийн хөрөнгийг дамжуулах шат дамжлага нэмэгдэх, эмзэг ядуу иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгохгүй байх зэрэг хүндрэлийг үүсгэж байна.

-Нийгмийн халамжийн арга хэмжээг 100 хувь улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Гадна, дотны төрийн бус багууллагууд, компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлгийн өрх, иргэдэд туслах зорилгоор зарцуулсан хөрөнгө, хандивийг хүлээн авч бүртгэх, зохих эзэнд нь хүргэх, хяналт тавих нэгдсэн зохицуулалтууд үгүйлэгдэж байна. Нийгмийн энтерпенерийг наад захын нийгмийн халамжийн үйлчилгээний хэрэгжих боломжгүй үйлчилгээнд нэвтрүүлж бага багаар ашиглаж боломжтой байна. Төсвөөс бага санхүүжилт авдаг ч зайлшгүй үйлчилгээ шаардлагатай талбарт тэдний асуудлыг шийдвэрлэхийг тулд нийгмийн нөөц, ашиглагдаагүй капиталыг олж харах чадвартай энтерпренерүүдээр дутаж байна. Тиймээс нийгмийн баялаг бүтээгчдийг дэмжих зайлшгүй шаардлагатай байна. Монгол улсад нийгмийн халамжийн системд хувийн хэвшлийн байгууллагын үүрэг оролцоог ашиглаж эхэлж байгаа нь нийгмийн энтерпренерийг нэвтрүүлэх суурь хүчин зүйл болж байна. 2018 оны байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж

хөнгөлөлт авсан иргэдийн тоо 1,772,300 байна. Дэлхийн банкны судалгаанаас нийгмийн халамжийн хөтөлбөрийг сайжруулах зорилгоор “Монгол дахь нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн шинжилгээ”-г хийжээ. Судалгааны дүнд Монгол улсын нийгмийн халамжийн зарцуулалтыг харьцангуй өгөөмөр гэж дүгнэсэн боловч зорилтот бүлэгтээ зөв хүрч чаддаггүй гэх дүгнэлт гаргасан байна. Өөрөөр хэлбэл МУ-д “Хавтгайрсан халамж”-ийн тогтолжоо нэгэнт бий болж, харин үүний үр дүнд бэлэнчлэх сэтгэлгээтэй ядуу иргэдийн тоо үржсээр байна. Дэлхий нийтийн жишгээс үзэхэд дундаж орлоготой гадны улс орнууд ДНБ-ийнхээ 1.6 орчим хувийг, өндөр орлоготой улс орнууд ДНБ-ийнхээ 1.9 орчим хувийг нийгмийн халамжийн системдээ зарцуулдаг бол манай хөгжиж буй орны хувьд орлого багатай хэдий ч ДНБ-ийнхээ 2.1 хувийг зарцуулж байгаа нь улсын төсөв алдагдалтай гарах цаашлаад өртэй гарахад нөлөөлж байна[4]. Төр хувийн хэвшлийн хамтран ажиллагаа нь энтерпренерийг явуулж буй нэг хэлбэр юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл нь нөөц ба туршлагад тулгуурлан ашиглах зорилготой төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хооронд байгуулсан эрх зүйн албан ёсны харилцаанд тулгуурласан ойлголт юм[5].

Монгол улсын нийгмийн халамжийн үйлчилгээ нь нийгмийн

суурь үйлчилгээний нэг томоохон хэсэг бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байгаа билээ. Хэдийгээр хувийн хэвшлийн салбараар дамжуулан нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх нь олон жилийн түүхтэй боловч 1990-ээд оны эхээр дэлхийн улс орнууд төр, хувийн хэвшлийн түншлэл нэвтрүүлснээр төр болон хувийн хэвшлийн үүрэг оролцоог шинээр тодорхойлсон халамжийн үйлчилгээ үзүүлэх шинэ хэлбэрийг бий болгосон. Мөн нийгмийн халамжийн үйлчилгээнд хувийн хэвшлийнхний үр ашигтай удирдлагын арга барил, үйл ажиллагаа нь үр ашигтай байлгах арга замуудыг нэвтрүүлснээр үйлчилгээний чанарыг сайжруулж, зардлыг хэмнэх ач холбогдолтой. Энэхүү түгшлэлийг ямар нэгэн бэлтгэлгүйгээр хөгжүүлнэ гэж байхгүй ба тодорхой бэлтгэл ажил шаардлагатай ба эдгээрийг гүйцэтгэхэд тодорхой хугацаа, хүчин чармайлт хэрэгтэй гэж үздэг[6].

1. Тохиромжтой хууль зүйн зохицуулалт ба бодлогын орчин

2. Бүтэц, зохион байгуулалтын ба чадавх бэхжүүлэх

3. Загварыг сайжруулах

4. Санхүүжилтын шинэ эх үүсвэрийг олох

5. Эрсдлийг зохистой хуваарилах

Нийгмийн энтерпренер ба түүнийг ашиглах арга зүй

Жон Эликингтон, Памела Хартиган нар нийгмийн энтерпренерийн бизнесийн бүтцийг нөхцөл байдал, эдийн загийн уур амьсгалтай холбогдуулан гурван өөр загварт багтдаг гэж үзжээ[7]. Үүнд:

1. Ашгийн бус ашиг сонирхол: Энэхүү загвар нь санхүүгийн болон бусад нөөцийг нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн шинэлэг байдлаар ашиглах.

2. Холимог ашгийн бус үйл ажиллагаа: Энэхүү зохион байгуулалтын бүтэц нь олон янзын хэлбэртэй боловч үүгээрээ онцлог юм. Холимог ашгийн бус хэсэг нь нийгмийн болон олон нийтийн зорилготой нийцүүлэхийн тулд бусад үйл ажиллагаагааны ашгийг ашиглахад бэлэн байдаг. Холимог ашгийн бус үйл ажиллагаа нь засгийн газар, зах зээлийн хямралыг шийдвэрлэхэд ихэвчлэн бий болдог. Учир нь зээл тусламж, бусад уламжлалт санхүү шаардахгүйгээр үйл ажиллагаа тогтвортой байлгахын тулд орлого бүрдүүлдэг. Энэ загвар ихэвчлэн хувь хүн гэхээсээ илүү томоохон байгууллагуудад хэрэгждэг бөгөөд олон төрлийн үйлдвэрлэлийн ашгаасаа тодорхой хэсгийг нийгэм, соёл, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд хөрөнгө оруулдаг.

3. Нийгмийн бизнесийн чиглэл: Нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар нийгмийн өөрчлөлтийг бий болгох зорилготой бизнесүүд багтана.


Нийгмийн халамжийн үйлчилгээний шинэчлэл нь инновацийг нэвтрүүлэх замаар шинэ хэлбэрийг бий болгох юм. Инновацийг амьдралд хэрэгжүүлэхийн тулд дараах 3 эх сурвалж шаардлагатай.

1. Нийгмийн салбарт төрийн байгууллагын мэргэжилтэнгүүд халамжийн үйлчилгээ үзүүлэх шинэ арга замыг олоход түлхэц өгдөг.

2. Хувийн хэвшлийн бизнесийн нийгмийн нөхцөл байдлыг сайжруулахад түлхэц үзүүлдэг.

3. Сайн дурын салбар нь нийгмийн энтерпренерийн хамгийн үржил шимтэй эх үүсвэр бөгөөд тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж байна. Энэ нь нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бизнесийн ур чадварыг хөгжүүлэхэд суралцдаг

Зураг 1. Нийгмийн энтерпренерийг эрхлэх эх үүсвэр



Эдгээр 3 хүчин зүйлийн нэгдлээс нийгмийн шинэчлэлт, өөрчлөлт гарч ирдэг. Нийгмийн халамж, бизнес эрхлэлтийг нэгтгэсэн тодорхойлолт нь нийгмийн бизнес эрхлэх буюу нийгмийн энтерпренер юм. Нийгмийн энтерпренер нь нийгмийн халамжийн үйлчилгээг ханган явуулах ур чадвар, нөөц бий

эсэх нь төр хувийн хэвшлийн байгууллагын уялдаа холбооноос хамаардаг. Нийгмийн энтерпренерт 3 үндсэн асуудал байдаг. Үүнд:

1. Яагаад нийгмийн энтерпренер нийгмийн инновацийн өөрчлөлтийг авчрах хэрэгтэйг тайлбарлах.

2. Хэрхэн бизнес эрхэлснээр нийгмийн зохион байгуулалтыг үүсгэж хөгжүүлэх?

3. Практикт гарсан үр дүн буюу халамжийн инновацийн талаар нийгмийн энтерпренерүүд засгийн газар болон хувийн хэвшлийн байгууллагад зөвлөх Нийгмийн энтерпренерийн үнэ цэнэ үндсэн 3 хэлбэрээр илэрдэг.

1. Богино хугацаанд нийгмийн бизнес эрхлэгчид ажлын байр бий болгох, төрийн зардлыг хэмнэх замаар эдийн засагт үр өгөөжөө үзүүлэх.

2. Дунд хугацаанд тэд төрийн байгууллагатай илүү үр бүтээлтэй хамтран ажиллаж халамжийн төлөв байдлыг шинэчлэх боломжит загварыг бий болгох чухал ач холбогдолтой юм.

3. Урт хугацаанд хувь нэмрээ оруулснаар нийгмийн капиталыг бий болгох чухал ач холбогдолтой.

Ашгийн төлөө бус тухайн нийгмийн асуудлыг төрийн оролцоогүйгээр шийдвэрлэх явдал бөгөөд нийгэм дэх ашиглагдахгүй капиалыг олж харан инновац болгон хөгжүүлж нэг нь нөгөөгөө тэтгэх үйл явц юм.

Зураг 2. Нийгмийн капиталын цикл



Төр өөрөө маш томоохон хэмжээний капиталыг эзэмшдэг. Тиймээс хувийн хэвшил үйл ажиллагаандаа төртэй хамтрах нь тэдэнд хялбар болж ирдэг.

Их британи улсын жишээг дурдахад 1998 онд нийгмийн энтэрпренерийг нийгмийн халамждаа нэвтрүүлсэн бөгөөд 400,000 гаруй нийгмийн төлөөх бизнес эрхлэгч байгууллага хөдөлмөр эрхлэлтийг 4%-ийг дангаараа хангаж жилд 29,5 тэрбум фунт стерлингийн орлого олж байгаа бөгөөд гол төлөв соёл, амралт, боловсрол, эрүүл мэнд, хувийн нийгмийн үйлчилгээний ажилд зарцуулж байна. Ингэснээр нийгмийн халамжийн ачаалал 30%-иар буурсан байна[8].

Нийгмийн халамжийн үйлчилгээ нь ихээхэн хавтгайрч иргэдийн бүтээлч байдлыг бууруулж тэднийг бэлэнчлэх сэтгэлгээнд автуулж байгаа учир тэдний амьдралын түвшин, бүтээлч байдлыг дээшлүүлэхийн тулд мөн

нийгмийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд нийгмийн энтэрпренерийг ашиглах боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Нийгмийн бизнес эрхлэх буюу нийгмийн энтэрпренер гэдэг нь анхаарлаа төвлөхүүлсэн нөөцийг нэгтгэн үнэ цэнийг бий болгох үйл явц юм. Энэхүү шинэ загварыг бий болгохын тулд ашиглагдаагүй нөөцийн тусламжтайгаар санхүүжилтийн эх үүсвэрийг үүсгэх замаар инновацийг бүтээж байгаа хэлбэр билээ. Ядуурлыг арилгах замаар нийгмийн үнэ цэнийг бий болгох, нийгмийн эрүүл мэнд, боловсролын чанарыг сайжруулах зэрэг олон эерэг үр дүн үүний хүлээлтэд багтаж буй юм.

НОМ ЗҮЙ

1. World social welfare Reform 2016
2. Ashoka and Scoll (1998)
3. Baron David P. “Компанийн нийгмийн харуцлага ба нийгмийн бизнес эрхлэх”. Эдийн засаг менежментийн сэтгүүл, 2004. х.631
4. World Bank 2018
5. Нийгмийн халамжийн үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх нь. Ч.Баатар. Эрдэм шинжилгээний өгүүлэл. 2011
6. Asian development bank, Public-Private handbook, 2008
7. Жон Элкингтон, Памела Хартиган. Ухаангүй хүмүүсийн хүч. 2008 х.31
8. The rise of social entrepreneur 1998